

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2022 ОНЫ ЖИЛИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ		Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжилт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён гэрээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага, зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), болон лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх	- Баримтжуулж, үр дүнг тооцож тайлагнасан байх	Жилдээ	Төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох “Нэг дусал” радио зөвлөмж, байршуулах материалыг Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсны дагуу байгууллагын дотоод сүлжээнд 34 радио зөвлөмжийг байршуулж албан хаагчдад байгууллагын фэйсбүүк групп болон чат группт, intranet.gov.mn, darkhan.gazar.gov.mn цахим хайгуудаар албан хаагч бүрт талаар мэдээллийг хүргэж танилцуулах ажлыг зохион байгуулсан. Мөн 2022 оны 11 сард байгууллагын фэйсбүүк хаягаар АТГ-ын бэлтгэсэн реклам 17ш, орон нутгийн 2ш, зурагт хуудас 22ш, нэвтрүүлэг 5ш, 19 ш видео, шторк болон богино хэмжээний киног байгууллагын үүдний телевизээр олон нийтэд түгээх ажлыг тус тус зохион байгуулсан.
		1.2.	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар, нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	- Дэмжиж хамтран ажилласан байх - Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх	Жилдээ	АТГ-аас санаачилсан Зөв зөв шударга зөв соён гэгээрүүлэх аян, мөн аймгийн Засаг даргын тамгын газраас Ёс зүйтэй, хүнд сурталгүй төрийн алба” аяны хүрээнд 2022 оныг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь “Ёс зүйтэй, хүнд сурталгүй, авлига ашиг сонирхлоос ангид цахим газрын харилцаа” уриаг хэрэгжүүлж

						ажиллаа.
		1.3.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах	- Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх, - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх	Жилдээ	Шударга ёс, хөгжил дэвшилд 110 мэдээллийн самбарыг ажиллуулж байгаа бөгөөд аймгийн төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, хүнд сурталын талаарх санал гомдол хүлээн авах хайрцгийг байгууллага дээр байршуулан ажиллаж байна. самбарт байгууллагын Мөн 7037-1212 утас, 11-11 гомдол, мэдээлэл хүлээн авах утасны дугаарыг байршуулан ажиллаж байна.
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулах	- Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Төлөвлө гөөнд туссан хугацаанд	- ГЗБГЗЗГ-аас Авлигатай тэмцэх газартай хамтран 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон Газрын удирдлагын хэлтсийн дарга нарт зориулсан авлигын эсрэг сургалтыг 2022.04.20-21-ны өдрүүдэд УБ хотод Удирдлагын академийн байранд танхимаар суралцсан. - 2022-01-07 өдөр Төрийн албан хаагчдын ёс зүй, цогц чадамжийн үндэсний жишиг хөтөлбөр боловсруулах сургалтанд ЭБАТ, Газрын дарга нар оролцсон. - 2022-2-22-23-ны өдрүүдэд аймаг, сумдын удирдах, ахлах ажилтануудыг чадавхижуулах цахим сургалтанд хамрагдсан. - 2022-06-16 өдөр Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллага, Авлигатай тэмцэх газраас хамтран төрийн албан хаагчдад "Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" цахим сургалтанд албан хаагчид хамрагдсан.
		2.2	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан	- Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх - Хамрагдсан хүүхэд	Жилдээ	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх ажил хийгдээгүй.

			иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж үр дүн тооцож, тайлагнах	залуус, иргэдийн тоо		
3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	3.1	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээг хэрэгжүүлэх	- Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	Тухай бүр	байхгүй.
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл санаачилга өрнүүлэх	4.1	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга, уриа, аянд нэгдэж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах	- Тодорхой арга хэмжээг хэрэгжүүлсэн байх	Жилдээ	Аймгийн ИТХурлаас 2022-03-21 өдөр батлагдсан “Дархан-Уул аймгийн авилга, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 2022 оны 10 сард гаргаж хүргүүлсэн.
		4.2	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах		Жилдээ	Энэ чиглэлийн гэрээ хэлэлцээр хийгдээгүй. Цаашид геодезийн хэмжилт зураглал, хянан баталгаа хийдэг хувийн хэвшлийн компаниудтай хамтран ажиллах гэрээнд тусгах ажлыг зохион байгуулна.
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн програм хангамжийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх	- Цахим хэлбэрт шилжсэн байх	Жилдээ	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд оруулсан барилга байгууламжийн мэдээллийн нийт бүртгэгдэх талбарын 14% бүртгэгдээгүй байснаас мэдээллийг нөхөн оруулах ажил 85% тай явагдаж байна. Мөн хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн програм хөгжүүлэлт хийгдэж байгаа тул шинээр ашиглалтанд орсон барилга байгууламжийн мэдээллийг маягтын дагуу цаасан хэлбэрээр бүртгэлжүүлж байна.
		5.2	Геодези, зураг зүйн	- Цахим хэлбэрт	Жилдээ	ГЗБГЗЗГ-аас Газар зүйн нэрийн зураг,

			бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, цахим үйлчилгээ үзүүлэх	шилжсэн байх		геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийн https://nsdi.gov.mn системийн цахимжуулалт, хөгжүүлэлтийн ажил хийгдэж байгаа цахим үйлчилгээ үзүүлэх ажил хүлээгдэж байна.
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг сайжруулах	6.1.	Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах	- Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх	жилдээ	1. “Егazar цахим системд нэвтрэх, хүсэлт гаргах, өргөдлийн явц харах, газрын кадастрын зураг, гэрчилгээ, гэрээ хэвлэх, үнэгүй газар өмчилсөн эсэх лавлагаа авах видео заавар 17 ширхэг”, “Газрын төлбөр, татвар тушаах видео заавар”, “Архитектур төлөвлөлтийн даалгавар авах видео заавар-ыг тус тус бэлтгэж байгууллагын болон сумдын даамлуудын олон нийтийн сүлжээний хуудсаар дамжуулан сурталчилсан. Мөн ухаалаг утасгүй иргэдэд зориулан 3 ширхэг гарын авлага, Газрын харилцааны цахим шилжилт, Газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан гаргах боломжтой хүсэлтүүдийн жагсаалт, хүсэлтийн маягт татаж авах, сумдын ТЖГЗБТ-нд санал өгөх холбоосын QR кодын постер хийж олон нийтийн газарт нааж, цахимаар түгээж хийсэн. Видео заавруудыг нийт 7060, 1 видеог дунджаар 504, постерыг нийт 8613, 1 постерыг дунджаар 1435 хүн үзсэн байна. 2. Газрын дуудлага худалдааны талаарх мэдээллийг 2021.02.02, 2021.06.18, 2021.11.10-ны өдөр орон нутгийн мэдээллийн Ди Би Эс, Ар Жи Би телевизээр тус тус мэдээлэл өгсөн. 3. Дархан-Уул аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=207 цахим хуудас болон фэйсбүүк, www.egazar.gov.mn

					цахим хуудсаар ил тод нээлттэй сурталчлах ажлыг зохион байгуулан ажилласан. Тухайн сард www.egazar.gov.mn цахим хуудаснаас 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлыг харах зааварыг орон нутгийн телевиз болох TV-12, RGB телевиз, DBS телевизээр газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны талаар орон нутгийн RGB телевизид олон нийтэд хүргэх мэдээлэл өгөх ажлыг тус тус зохион байгуулж ажилласан.	
		6.2	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	4. Байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудсанд 33 ширхэг шинэ мэдээ, 81 удаагийн шинэчлэлт, өөрчлөлт хийсэн. Байгууллагын фэйсбүүк хуудсанд 59 ширхэг шинэ мэдээ, санал асуулга 2 ширхэг, Egazar цахим системийг хэрхэн ашиглах талаар 18 ширхэг, Архитектур төлөвлөлтийн даалгаврыг цахимаар хэрхэн авах тухай зааврын видео 1 ширхэг, БХБЯ-ны мэдээлэл 29 ширхэг, ГЗБГЗЗГ-ын мэдээлэл 87, Орон нутгийн ТВ-ын болон бусад төрийн байгууллагын мэдээлэл 66, Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын мэдээлэл 229, АТГ-ын Авлигаас урьдчилан сэргийлэх постер, шторк 34-г хуваалцаж түгээсэн.
					Байгууллагын эрхэм зорилгыг http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=151 үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=165 цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	

		байрлуулан тухай бүр шинэчлэх			
	6.3	Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэл, холбогдох утас, өрөөний дугаар зэрэг мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан ажилтны нэр, албан тушаал, утасны дугаар, факсын дугаар, албаны мэйл хаяг, байгууллагын ажиллах цагийн хуваарь, байгууллагын албан ёсны хаяг зэрэг мэдээллийг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/contact.php цахим хуудсанд байршуулсан. Мөн ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэл, холбогдох утасны дугаар зэрэг мэдээллийг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/read.php?module=read&mid=462 цахим хуудсанд болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан шинэчлэн ажиллаж байна.
	6.4	Салбарын болон байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Салбарын болон байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг www.darkhan.gazar.gov.mn цахим хуудасны хууль эрх зүйн цонхонд байршуулсан. Мөн салбарын дүрэм, журам, зааврыг байгууллагын мэдээллийн самбарт тухай бүрт нь байршуулж олон нийтэд хүргэж ажиллаж байна.
	6.5	Иргэн, хуулийн этгээд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Иргэн, хуулийн этгээд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт болон ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэл, холбогдох утасны дугаар зэрэг мэдээллийг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/read.php?module=read&mid=462 цахим хуудсанд болон байгууллагын мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулан шинэчлэн ажиллаж байна.
	6.6	Иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх албан	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан ажилтны нэр, албан тушаал,

		хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх			утасны дугаар, факсын дугаар, албаны мэйл хаяг, байгууллагын ажиллах цагийн хуваарь, байгууллагын албан ёсны хаяг зэрэг мэдээллийг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/contact.php цахим хуудсанд байршуулсан. Мөн иргэн, хуулийн этгээд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт болон ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэл, холбогдох утасны дугаар зэрэг мэдээллийг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/read.php?module=read&mid=462 цахим хуудсанд болон байгууллагын мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулан шинэчлэн ажиллаж байна.
	6.7	Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг цахимаар болон бусад хэлбэрээр хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, хариуг хугацаанд нь өгөх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Байгууллагын intranet.gov.mn , www.egazar.gov.mn цахим системээр болон darkhan@gazar.gov.mn мэйл хаягаар өргөдөл, гомдол, хүсэлт мэдээллийг хүлээн авч байна. 2021.01.02-2021.12.05-ны өдрийн хооронд абле программд нийт 1193 албан бичиг /хариутай 864/, 350 өргөдөл, гомдол 6 /хариутай 325/ ирсэнээс 801 албан бичиг, 292 өргөдөл, 6 гомдол шийдвэрлэн, 63 албан бичиг, 27 өргөдөл хяналтанд бүртгэгдсэн.
	6.8	Тухайн зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрх эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Геодези, зураг зүйн мэргэжлийн байгууллагын жагсаалтыг http://www.darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=132 , газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагуудын жагсаалтыг http://www.darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=67 цахим хуудсанд болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.
	6.9	Үйлчлүүлэгчээс авч буй	- Мэдээлэл бүрэн	Тухай	Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр,

	төлбөр, хураамжийн үнэ, тарифийн талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах	тавигдсан байх	бүр	хураамжийн үнэ, тарифийн талаарх мэдээллийг http://www.darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=123 цахим хуудсанд болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан.
6.10	Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлэх	- Боломжийг бүрдүүлсэн байх	Тухай бүр	- Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулах төсөлд санал авахаар байгууллагын www.facebook.com/darkhangazar фэйсбүүк хуудсанд линкийг байршуулсан. - мөн Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 3, 4, 6 дугаар хавсралтыг шинэчлэх, хот тосгон бусад суурины газрын үнэлгээний бүс 1 га газрын суурь үнийг шинэчлэн тогтоох төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т газрын төлбөр тооцох итгэлцүүрийг сум, дүүргийн ИТХ тогтооно гэж заасан байдаг. Энэ хэсэгт “сум, дүүргийн” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Үүнтэй холбоотой Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумын газрын төлбөрийн хэмжээг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулах олон нийтээс санал авахаар байгууллагын www.facebook.com/darkhangazar фэйсбүүк хуудас, http://darkhan.gazar.gov.mn/read.php?module=read&mid=487 цахим системд санал авах линкийг байршуулсан. Цахим хаягаар ирсэн санал шүүмжлэлийг цаг

				тухай бүрт хариу өгч ажиллаж байна.
	6.11	Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	- Тодорхой арга хэмжээг хэрэгжүүлсэн байх	Тухай бүр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Egazar.gov.mn системийг нэвтрүүлж, газрын харилцааны үйлчилгээг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн цахимаар авдаг болсон. Үүнд: -Газрын эрхээ бусдад шилжүүлэх, -Газрынхаа зориулалт өөрчлөх, -Газрынхаа талбайн хэмжээ өөрчлөх -Гэрчилгээгээ нөхөн авах, -Гэрчилгээгээ барьцаанд бүртгүүлэх, -Гэрчилгээний хугацаа сунгах зэрэг 17 хүсэлтээ цахимаар илгээх боломжтой болсон. Мөн шинээр хаана газар олгохоор төлөвлөлтөнд орсныг харах, тухайн орон нутгийнхаа газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд саналаа өгөх боломжтой юм. Мөн ГЗБГЗЗГ-ын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”, Газрын нэгдмэл сангийн удирдлагын www.egazar.gov.mn цахим системийг 2021.10.01-2021.12.01-ний өдрийн хооронд төрийн 17 байгууллагын 253 албан хаагчдад, мөн байгууллага дээр egazar.gov.mn цахим үйлчилгээ авдаг төвийг байгуулж 834 иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл зөвлөгөө, сургалтыг зохион байгуулсан.
	6.12	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр Байгууллагын http://www.darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=335 цахим хуудсанд 7 хоног, сар, хагас жилийн тайланг оруулж байршуулан олон нийтэд мэдээлж байна.
	6.13	Байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	1 дүгээр сард Байгууллагын хагас жилийн болон бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг

		байгууллагын цахим хуудсанд мэдээлж байх			байгууллагын http://www.darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=335 цахим хуудсанд байршуулсан.	
	6.14	Байгууллагын “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г байгууллагын цахим хуудсанд мэдээлж байх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	1 дүгээр сард	2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021.03.18-ны өдөр байгууллагын даргаар батлуулж байгууллагын http://www.darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=375 цахим хуудасны ил тод байдал, авлигатай тэмцэх цонхонд олон нийтэд мэдээлсэн.	
	6.15	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжилт, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг байгууллагын цахим хуудсанд мэдээлж байх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	1 дүгээр сард	Байгууллагын 2022 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны бүтэн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүтэн жилээр гаргаж байгууллагын http://www.darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=375 цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн.	
7	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	7.1	Байгууллагад гарсан сул орон тооны зарыг цахим хуудас болон холбогдох байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд зарлах	- Зарлал тавигдсан байх	Тухай бүр	Байгууллагын 2 сул орон тооны судалгааг болон зарыг 2022 оны 10 дугаар сарын 19 өдөр ... тоот албан бичгээр Аймаг дахь төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн. .
		7.2	Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Батлагдсан тухай бүрт	Байгууллагын даргын 2017.02.13-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан албан хаагчдын ёс зүйн дүрэм, байгууллагын ёс зүйн хорооны ажиллах журам болон ЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоол, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг 2022 онд шинэчлэн http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=124 цахим хаяг болон мэдээллийн самбарт байршуулсан.
		7.3	Байгууллагын хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Батлагдсан тухай	Хүний нөөцийн стратеги төлөвлөөг хэрэгжүүлж ажилласан. Хэрэгжилтийг ГЗБГЗЗГ-т 2022 оны 12 сард багтаан

			журмыг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх		бүрт	altaa_gov@yahoo.com цахимаар хүргүүлэн. ГЗБГЗЗГ-ын даргын тушаалаар “Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ийг дагаж мөрдөж, байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=124 цахим хуудсанд байршуулсан.
		7.4	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Батлагдсан тухай бүрт	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, Албан хаагчдын сургалтын төлөвлөгөө, Эцэг эхийн зөвлөлийн төлөвлөгөө, Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө, Хяналт шинжилгээ үнэлгээний үйл ажиллагааны төлөвлөгөө, Бүх нийийн эрх зүйн боловсролыг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөө, "Жендерийн тэгш байдлыг хангах" чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=154 цахим хуудсанд байршуулж мэдээлж байна.
		7.5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Батлагдсан тухай бүрт	Байгууллагын нийт 20 албан хаагчдыг гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээг дүгнэх, ажлын гүйцэтгэлийн үнэлэхдээ ГЗБГЗЗГ-аас 2022 оны 12 сарын 10 дотор батлагдсан журмыг хэрэгжүүлж үнэлгээг шалгуур үзүүлэлтийн оноог өгч дүгнэсэн байна.
8	Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах	8.1	Тухайн жилийн төсөв мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 01 дүгээр	Тухайн жилийн батлагдсан төсвийг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=45 цахим хуудас болон

		www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;		сарын 10-ны өдрийн дотор;	шилэн дансны https://www.shilendans.gov.mn цахим хуудсанд цаг хугацаанд нь байршуулсан.
8.2	Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 04 дүгээр сарын 01-ны өдрийн дотор;	Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=45 цахим хуудас болон шилэн дансны https://www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан.	
8.3	Дараа жилийн төсвийн төслийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;	Дараа жилийн төсвийн төслийг хуулийн хугацаанд шилэн дансанд https://www.shilendans.gov.mn мэдээллэсэн.	
8.4	Жилийн эцсийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор;	Жилийн эцсийн санхүүгийн тайланг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=45 цахим хуудас болон шилэн дансны https://www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаанд нь байрлуулан мэдээллэсэн.	
8.5	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор;	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын http://darkhan.gazar.gov.mn/reads.php?module=read&mid=45 цахим хуудас болон шилэн дансны https://www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаанд байршуулсан. Аудитын итгэл хүлээн авсан.	
8.6	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	өөрчлөл т орсноос хойш ажлын	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны https://www.shilendans.gov.mn цахим	

			www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;		14 хоногт	хуудсанд өөрчлөгдсөн тухай бүр нь байршуулсан.
		8.7	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;	2022 онд худалдан авах ажиллагааны төсөв суугдаагүй.
		8.8	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Сар бүрийн 08-ны дотор	2022 оны жилийн байдлаар Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл байхгүй болно.
		8.9	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Сар бүрийн 08-ны дотор	Тендерийн үйл ажиллагаа байхгүй.
		8.10	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээ байхгүй бөгөөд шилэн дансны https://www.shilendans.gov.mn цахим хуудсанд орлогын дансны мэдээллийг өссөн дүнгээр мэдээлж байна.

		цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;			
	8.11	Худалдан авах ажиллагааны тайланг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Бүтэн жилээр	2022 оны жилийн байдлаар тендер худалдан авалтын үйл ажиллагаа байхгүй.
	8.12	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг 2022 оны 12 дугаар сарын сарын 02-ны өдрийн байдлаар 54 мэдэгдлийг албан хаагчид гаргаж, АТГ-ын мэдүүлэг бүрдүүлэлтийн программд шивэж оруулсан.
	8.13	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд байрлуулан мэдээлж байх;	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Тухай бүр	2022 онд төрийн хэмнэлтийн хуулиар төсвийн хуваарьт өөрчлөлт орсон ба 426,6 мян төг нэмэгдсэн. 3,0 сая төгрөгийн өглөгтэй байсныг барагдуулахаар ажиллаж байгаа. Мөн байгууллагын даргын А/24 А/28 дугаар тушаалуудаар хөрөнгө зарцуулж гүйцэтгэлийг шилэн дансанд https://www.shilendans.gov.mn мэдээлсэн.
	8.14	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны www.shilendans.gov.mn	- Мэдээлэл бүрэн тавигдсан байх	Сар бүрийн 08-ны дотор	2021 онд болон 2022 онд байгууллагын орон тоонд өөрчлөлт ороогүй.

		цахим байрлуулан мэдээлж байх;	хуудсанд			
--	--	-----------------------------------	----------	--	--	--

Хэрэгжилт гаргасан:

ЭБАТ:

Г.Нямдорж

2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр